

“Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хараат бус гишүүн С.Цэнд-Аюушийн 2023 оны эхний хагас жилийн ажлын тайлан

Монгол Улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон бусад холбогдох хууль, Монгол Банкны Ерөнхийлөгчийн 2021 оны 86 тоот тушаалаар батлагдсан “Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”-ын дагуу “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хараат бус гишүүний үүргийг гүйцэтгэж 2023 оны эхний хагас жилийн байдлаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 9 удаагийн хуралд биечлэн оролцож, банкны өмнө тулгамдсан 30 гаруй асуудлыг шийдвэрлэхэд өөрийн санал дүгнэлтээ гаргаж ажиллаа.

Тайлант хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн болно. Үүнд: Төрийн банк ХК-ийн 2022 оны жилийн эцсийн болон 2023 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны тайлан, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2022 оны жилийн эцсийн болон 2023 оны 1 дүгээр улирлын тайлан, Төрийн банкны гүйцэтгэх захирал Ө.Гантөрийн контрактын гэрээний үүргийн биелэлт, Төрийн банкны 2023-2025 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөө, 2023 оны бизнес төлөвлөгөө, 2023 оны санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, Банкны 2023 оны үйл ажиллагааны эрсдэлийн аппетит буюу эрсдэлээс хүлээж болзошгүй алдагдлын хязгаар тогтоох тухай, “Төрийн банк” ХК-ийн 2023 оны “Тогтворжуулах төлөвлөгөө”, 2023 оны Санхүүгийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Төрийн банкны бүтцийг шинэчлэн батлах тухай болон банкны холбогдолтой дүрэм, журам, зааврыг шинэчлэн батлах зэрэг асуудлуудыг хэлэлцэхэд хараат бус гишүүний үүргийн дагуу санал дүгнэлтээ хараат бусаар гаргаж ажиллаа.

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны хурлыг 6 удаа удирдан хуралдуулж 20 орчим асуудал хэлэлцэн асуудал бүр дээр шийдвэр гаргаж ажиллаа. Үүнд: Банкны Дотоод аудитын газрын 2023-2025 оны дунд хугацааны төлөвлөгөө, 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах, Дотоод аудитын газрын 2022 оны жилийн эцсийн болон 2023 оны 1 дүгээр улирлын тайлан, Грант Тронтон аудит ХХК-ийн Төрийн банкны 2022 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийсэн тайлан, Дотоод аудитын газрын дүрэм, чиг үүрэг, бүтэц болон ТУЗ-өөр хэлэлцүүлэх бүхий л асуудлыг Аудитын хорооны хурлаар хэлэлцүүлж шийдвэр гаргасан.

Банкны хөрөнгө оруулалтын 2022 оны гүйцэтгэл, Дотоод аудитын газраас хөрөнгө оруулалтын байдалд хийсэн шалгалтын дүнг хэлэлцэж урьд оноос шилжсэн дуусаагүй барилгын ажлыг 2023 онд бүрэн дуусгаж ашиглалтад оруулах, барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах, техникийн хяналт, хэмжин шалгалтыг тогтмол хийж, батлагдсан зураг, төсөв, норм, дүрмийн дагуу гүйцэтгэлийг хянан баталгаажуулж, санхүүжүүлэх, Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаврын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллахыг үүрэг болгосон.

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны ээлжит 4 хуралд оролцож банкны эрсдэлийн удирдлагын чиглэлээр 2022 оны жилийн эцсийн болон 2023 оны 01 дүгээр улиралд хийгдсэн ажлын тайлан, 2023 оны 1-р улирлын Чанаргүй активын тайлан, ТУЗ-ийн дэргэдэх ЭУХ-ноос өгсөн үүрэг даалгаврын биелэлт, Актив пассивын удирдлагын хорооны ажлын тайлан зэрэг асуудлыг хэлэлцсэн. Банкны активын чанарыг сайжруулах, нийт активт эзлэх чанаргүй зээлийг бууруулах, хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх ажлыг эрчимжүүлэх, ашиглан, залилан гаргуулахгүй байх, цаашид болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар удирдамж чиглэл өгч ажиллаа.

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо, цалин урамшууллын хорооны 2 хуралд оролцож Банкны ажилтнуудын цалин, урамшуулал болон “Гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах, дүгнэх, урамшуулал олгох журам”-ын төсөл, “Гүйцэтгэх захиралтай байгуулах онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний загвар”-ын төслийг хэлэлцэж, ТУЗ-ийн хуралд оруулж шийдвэрлүүлсэн.

СБД-ийн “Тавин мянгат” тооцооны төв, Чингэлтэй дүүргийн “Занабазар салбар”-ын ажилтай танилцаж, тайлангаа ТУЗ болон Аудитын хороогоор хэлэлцүүлэн үүрэг даалгавар өгсөн.

Хөрөнгө оруулалтыг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих, тайлагнах талаарх сургалтыг зохион байгуулж хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан ажилтнуудыг хамруулсан.

Эмчийн ерөөг өргөтгөж тохижуулах үүрэг өгч банкны ажиллагсдын үйлчлүүлэх нөхцөлийг сайжрууллаа.

Миний бие банкны ТУЗ-ийн хараат бус гишүүний үүрэг хариуцлагын дагуу ээлжит болон ээлжит бус хуралд тухай бүр биечлэн оролцож ТУЗ-өөр хэлэлцэгдэж байгаа баримт материалуудтай нэг бүрчлэн танилцаж, бүхий л асуудалд санал, дүгнэлтээ хараат бусаар гаргаж, албан үүргээ бүрэн биелүүлж ажиллаж байна.

Тайлан бичсэн: С.Цэнд-Аюуш /ТУЗ-ийн хараат бус гишүүн/